



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2017/10



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 280, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 185 байгаагийн 111 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 29 буюу 18.6 хувиар, өмнөх сараас 4 буюу 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Аравдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 33 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 21 иргэн ажилд зуучлагдсаны 4 буюу 19.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үед байгаагүй болно.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 6, 25-34 насны 32, 35-44 насны 78, 45-54 насны 38, 55 түүнээс дээш насны 31 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 10 сарын байдлаар 318 эх амаржиж, 324 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 82 буюу 20.5 хувиар, төрсөн хүүхдийн тоо 82 буюу 20.2 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 84, бүртгүүлсэн гэр бүл 60, цуцалсан гэр бүл 24 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 6 буюу 33.3 хувиар өсч, нас баралт 9 буюу 9.7 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 10 буюу 14.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 2 хүүхэд үрчлэгдсэн.



Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 495 хүн шилжин ирж, 397 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 11.0 хувиар, шилжин явалт 17.8 хувиар тус тус буурчээ.

Зураг 1.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2017 оны эхний 10 сарын байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 7193.2 сая төгрөг, зарлага 8974.9 сая төгрөг болсон байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 109.0 хувьтай, зарлагын гүйцэтгэл 100.5 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний 10 сарын байдлаар 4256 хүнд 1133.9 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 383 хүн буюу 8.3 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 63.3 сая төгрөг буюу 5.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2017 оны эхний 10 сарын байдлаар 1186 хүн хамруулж 586.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 338 хүн буюу 22.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 83.7 сая төгрөг буюу 12.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2017 оны эхний 10 сарын байдлаар 3070 хүн хамруулж 547.5 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 45 хүн буюу 1.4 хувиар буурч, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 147.0 сая төгрөг буюу 36.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны 10 дугаар сарын мэдээгээр 199 байгууллагын 5617 даатгуулагч иргэн, үүнээс 717 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 410



даатгуулагчийн дундаж цалин 602.5 мянган төгрөг, төсөвт 55 байгууллагын 1747 даатгуулагчийн дундаж цалин 609.8 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 660 даатгуулагчийн дундаж цалин 1217.8 мянган төгрөг, 113 ХХКомпаний 1884 даатгуулагчийн дундаж цалин 685.0 мянган төгрөг, бусад 18 аж ахуйн нэгж байгууллагын 199 даатгуулагчийн дундаж цалин 272.5 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2017 оны эхний 10 сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны эхний 10 сарын байдлаар 345 эх амаржиж, 2016 оны мөн үетэй харьцуулахад 39 буюу 10.2 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 346 үүнээс 185 нь хүү, 161 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 41 буюу 10.6 хувиар буурсан байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 3 бүртгэгдсэн байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар





Халдварт өвчин эхний 10 сарын байдлаар 161 буюу 10000 хүн амд 96.6 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 106 тохиолдлоор буурчээ.


Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 89201 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 16954 хүнээр буюу 16.0 хувиар, 3917 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 199 хүнээр буюу 4.8 хувиар буурсан байна.

2017 оны эхний 10 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 5158, халдварт өвчин 161 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 10 сарын байдлаар 152 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16 буюу 9.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тодорхой хэмжээгээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 40 байгаа нь өмнөх оны мөн үеэс 90.5 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 54.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 21 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 103 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 10 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны эхний 10 сарын байдлаар 278.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 195.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 74.0 сая төгрөгөөр буюу 21.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 76.0 сая төгрөг буюу 28.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны эхний 10 сарын байдлаар давхардсан тоогоор 570 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 173 хүнээр буюу 23.3 хувиар буурсан байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 10 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2017 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар, 2016 оны жилийн эцсээс 3.8 хувиар, өмнөх сараас 0.3 хувиар өсч байна.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 10 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2017.X}{2016.X}$	$\frac{2017.X}{2016.XII}$	$\frac{2017.X}{2017.IX}$
Ерөнхий индекс	104.2	103.8	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	107.0	104.9	100.1
Согтууруулах ундаа, тамхи	103.0	103.0	100.0
Хувцас, бөс бараа, гутал	102.4	102.4	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	100.7	100.7	99.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	104.7	104.7	103.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.1	102.1	100.0
Тээвэр	111.0	111.0	100.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	99.9	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.7	99.7	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	99.3	99.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	102.9	102.9	100.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ


**VI. Төсөв санхүү**

2017 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 11970.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 12251.3 сая төгрөг болж 102.3 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 13981.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 11400.9 сая төгрөг болж 81.5 хувийн гүйцэтгэлтэй байна.


2017 оны эхний 10 сарын байдлаар авлагын үлдэгдэл 8.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 79.4 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй, газар тариалан**


Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 185558 хээлтэгч малын 141527 буюу 76.3 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 99.0 хувьтай байна. 2017 оны эхний 10 сарын байдлаар 2195 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 5.2 дахин бага байна. Том малын зүй бус хорогдлын 19.7 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1. Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, толгойгоор






Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, толгойгоор



2017 онд аймгийн хэмжээнд нийт 38.7 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 5.7 га талбайгаар буюу 24.9 хувиар, хүнсний ногоо 1.0 га талбайгаар буюу 5.4 хувиар, тэжээлийн ургамал 5.9 га талбайгаар буюу 2.4 дахин буурсан байна.


Зураг VII.3.Тариалсан талбай, 2017 оны байдлаар, га



10 дугаар сарын ургац хураалтын мэдээгээр аймгийн хэмжээнд 17.2 га талбайгаас 100.6 тн төмс, 17.2 га талбайгаас 140.7 тн хүнсний ногоо, 4.3 га талбайгаас 27.8 тн тэжээлийн ургамал хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс хураалт 2.9 хувиар, хүнсний ногоо 16.6 хувиар их байна.



Зураг VII.4.Хураасан ургац, 2017 оны 10 дугаар сарын байдлаар, тн



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны эхний 10 сарын байдлаар 39.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.1 тэрбум төгрөг буюу 11.5 хувиар, оны үнээр 41.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2 тэрбум төгрөг буюу 21.3 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 89.7 хувь буюу 35.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 91.0 хувь буюу 37.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1.Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр





IX. Цаг агаарын мэдээ 10 дугаар сард:

Хур тунадас: Энэ сард нийт 3 удаа бороо орж 8.3 мм хур тунадас орсон байна.

Салхи: Ихэнх хугацаанд 5 -10 м/сек, зарим үед 12-16 м/сек хүрч салхилсан.


Агаарын температур: Дунджаар 2 хэм хүйтнээс 13.5 хэм дулаан байлаа.

2017 оны 11 дүгээр сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ


Уур амьсгалын агаарын температурын сарын дундаж 7-12 хэм хүйтэн байдаг бөгөөд олон жилийн дунджаас 1.0-1.5 хэмээр дулаан байх төлөвтэй.

Говьсүмбэр аймгийн нутгаар энэ сард орох хур тунадас нь олон жилийн дунджаас бага байх төлөвтэй. Нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр зарим газраар цас, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн өмнөд хэсгээр бага зэргийн цас орох төлөвтэй байна.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 14-16 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.



1 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж (°C)



3 дугаар зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	387	346	89.4
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	156	185	118.6
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	267	161	60.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	168	152	90.5
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	12440.5	12251.3	98.5
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	11753.9	11400.9	97.
Авлага	сая.төг	15.9	8.3	52.2
Өглөг	сая.төг	217.0	79.4	36.6
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	35621.2	39681.2	111.4
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	33844.3	41041.8	121.3
Төллөсөн хээлтэгч	толгой	151504	141527	93.4
Гарсан төл	толгой	152690	142340	93.2
Хорогдсон төл	толгой	3396	1425	42.0
Бойжсон төл	толгой	149294	140915	94.4
Том малын зүй бусын хорогдол	толгой	11488	2195	19.1



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	313	280	89.5
Үүнээс: эмэгтэй	219	178	81.3
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	156	185	118.6
Үүнээс: эмэгтэй	108	111	102.8
Ажлын байрны захиалга	99	33	33.3
Ажилд зуучлагдсан иргэд	0	21	*
Үүнээс: эмэгтэй	0	4	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
Амаржсан эх	400	318	79.5
Төрсөн хүүхэд	406	324	79.8
Үрчлэгдсэн хүүхэд	5	2	40.0
Бүртгүүлсэн гэр бүл	70	60	85.7
Цуцалсан гэр бүл	18	24	133.3
Нас баралт	93	84	90.3
Шилжин ирсэн	556	495	89.0
Шилжин явсан	471	387	82.2

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сангийн төрөл	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
ЭМНД-ын сангийн орлого, сая.төг	6 321.3	7 193.2	113.8
ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг	7 372.0	8 974.9	121.7

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-X		2017 I-X		$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	4 639	1 070.6	4 256	1 133.9	91.7	115.6
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 524	670.1	1 186	586.4	77.8	87.5
Халамжийн тэтгэвэр	335	322.8	264	318.9	78.8	98.8
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 189	347.3	922	267.5	62.5	77.0
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	3 115	400.5	3 070	547.5	95.6	136.7
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	680	62.9	987	175.6	145.1	279.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	281	64.2	222	47.2	79.0	73.5
Нийгмийн халамжийн үйлчилгээ	468	34.3	379	35.7	81.0	104.1
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	496	66.0	250	111.9	53.4	169.5
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	7	11.3	5	10.0	71.4	88.5
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 183	161.7	1 227	167.0	103.7	103.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
Төрсөн эх	384	345	89.8
Амьд төрсөн хүүхэд	387	346	89.4
Эрэгтэй	193	185	95.9
Эмэгтэй	194	161	83.0
Амьгүй төрсөн хүүхэд	2	2	100.0
Нийт нас баралт	60	70	116.7
Эмнэлгийн нас баралт	14	5	35.7
Хоног болоогүй нас баралт	8	5	62.5
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	6	2	33.3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	3	150.0
Эмчлэгдсэн өвчтөн	4 116	3 917	95.2
Амбулаторийн үзлэг	106 155	89 201	84.0
Халдварт өвчин	267	161	60.3

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 10 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	168	152	90.5
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	77	76	98.7
Өмчлөх эрхийн эсрэг	57	53	93.0
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	7	3	42.9
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	14	127.3
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	4	3	75.0
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	7	1	14.3
Бусад гэмт хэрэг	5	2	40.0



Гэмт хэрэгт <u>холбогдог</u> сод	172	154	89.5
15 хүртэлх насны	1	6	600.0
16-34 насны	116	92	79.3
35 ба түүнээс дээш насны	55	56	101.8
Боловсрол – Дээд	30	29	96.7
Боловсрол - Тусгай дунд	18	6	33.3
Боловсрол – Бүрэн дунд	64	45	70.3
Боловсрол – Бүрэн бус дунд	32	42	131.3
Боловсрол – Бага	19	13	68.4
Боловсролгүй	8	19	237.5
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	5	11	220.0
Ажилгүй иргэд үйлдсэн	75	67	89.3
Эмэгтэй хүн оролцсон	32	22	68.8
Хүүхэд оролцсон	6	15	250.0
Бүлгээр үйлдсэн	25	12	48.0
Согтуугаар үйлдсэн	60	45	75.0
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	168	152	90.5
Гудамж талбайд	44	45	102.3
Гэмт хэргийн улмаас нас барсан	4	9	225.0
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	108	103	95.4
Учирсан хохирол / сая.төг /	352.0	278.0	79.0
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	271.0	195.0	72.0

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Нийт орлого	12 440.5	12 251 .3	98.5
Урсгал орлого	3 990.4	4 734 .6	118.6
Татварын орлого	3 446.8	3 610 .8	104.8
Татварын бус орлого	543.6	1 123.9	206.8
Тусламжийн орлого	8 450.1	7 516.7	89.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Нийт зарлага	11 753.9	11 400.9	97.0
Урсгал зардал	9 830.3	10 023.4	102.0
Хөрөнгийн зардал	1 923.6	1 377.5	71.6

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Авлага	15.9	8.3	52.2
Өглөг	217.0	79.4	36.6
Төсөвт байгууллагын тоо	47	49	104.3
Төсөвт байгууллагын ажиллагсад	751	783	104.3

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Бүгд	151 504	141527	93.4
Ингэ	193	120	62.2
Гүү	4 247	4 305	101.4
Үнээ	4 122	3 984	96.7
Эм хонь	73 144	69 113	94.5
Эм ямаа	69 698	64005	91.8

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Дүн	151 504	141527	93.4
<u>Баянтал</u>	23 933	21 720	90.8
Сүмбэр	112 612	102 643	91.1
<u>Шивээговь</u>	14 959	17 164	114.7



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Бүгд	149 294	140915	94.4
Ботго	181	116	64.1
Унага	4 190	4 286	102.3
Тугал	3 972	3 952	99.5
Хурга	72 343	68 817	95.1
Ишиг	68 608	63 744	92.9

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Дүн	149 294	140915	94.4
<u>Баянтал</u>	23 786	21 801	91.7
Сүмбэр	110 818	101 896	91.9
<u>Шивээговь</u>	14 690	17 218	117.2

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Бүгд	11 488	2 195	19.1
Тэмээ	1	3	300.0
Адуу	305	30	9.8
Үхэр	474	105	22.2
Хонь	4 098	814	19.9
Ямаа	6 610	1 243	18.8

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Дүн	11 488	2 195	19.1
<u>Баянтал</u>	1 981	274	13.8
Сүмбэр	6 508	1 838	28.2
<u>Шивээговь</u>	2 999	83	2.8



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Бүгд	3 617	432	11.9
Тэмээ	0	0	*
Адуу	213	7	3.3
Үхэр	168	27	16.1
Хонь	1 383	210	15.2
Ямаа	1 853	188	10.1

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Дүн	3 617	432	11.9
<u>Баянтал</u>	158	34	21.5
<u>Сүмбэр</u>	700	377	53.9
<u>Шивээговь</u>	2 759	21	0.8

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Нийт	35 621.2	39 681.2	111.4
Нүүрс олборлолт	34 155.6	35 607.4	104.3
Боловсруулах үйлдвэр	69.2	2 363.5	3 415.5
Цахилгаан, дулааны эрчим хүч	1 396.4	1 710.3	122.5

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I-X}{2016 I-X} \%$
Нийт	33 844.3	41 041.8	121.3
Нүүрс борлуулалт	32 349.1	37 297.5	115.6
Боловсруулах үйлдвэр	98.8	2 175.3	2 201.7
Цахилгаан, дулаан эрчим хүч	1396.4	1 569.0	112.4



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	$\frac{2017 I - X}{2016 I - X} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	32 349.1	37 297.5	115.6
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	34 155.6	35 607.4	104.3
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/ Ажиллагсад	1 484.9 595	1 575.8 556	106.1 93.4

Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017